

**ЯГААН ЦЭЭНЭ (PAEONIA ANOMALA L) УРГАМЛЫН
ХЭРЭГЛЭЭГ ЭХ СУРВАЛЖААС ТОДРУУЛАХ НЬ**

T.Ариунжаргал¹, Э.Сансархуяг²,
Л.Хүрэлбаатар³, Г.Одонтуяа⁴, Ш.Болд⁵
^{1,2,3,4}ЭЗШУИС, ⁵МАЯА

**ELUCIDATING THE USES OF THE PLANT PAEONIA ANOMALA. L
FROM THE ANCIENT MEDICAL BOOKS**

Ariunjargal.T¹, Sansarkhuyag.E²,
Khurelbaatar.L³, Odontuya.G⁴, Bold.Sh⁵
Mongolian University of Pharmaceutical Sciences^{1,2,3,4}
Mongolian Academy of Medical Science⁵



Background

It is important to determine and study in detail the action of the main chemical and secondary components contained in pink sedum against the disease. In particular, it is of great practical importance to clarify the use of the plant from ancient medical books and scriptures and to determine which of the six main diseases were used in traditional medicine.

Purpose

Comparing the information of the ancient medical books written by Mongolian doctors and scientists, who wrote about Paeonia anomala L., to clarify the taste, power, and quality.

Research materials and methods

1. Research materials

- Sumbe khamba Ishbaljir. gso dpyad bdud rtsi 'i chu rgyun gyi cha lag gi nang tshan gyi sman so so'i mngon brjod dang ngos 'dzin shel dkar me long. *Wooden printing block with Tibetan script*.
- Toin Jambaldorj. gso byed bdud rtsi'i 'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so. *Wooden printing block with Tibetan script*.

2. Research methods

Methods of textual analysis for ancient books and checklist methods were used in the study.

Conclusion

The use of Paeonia anomala L. has been enriched with indications for use in traditional medicine, Mongolian folk medicine, Russian folk medicine, and Chinese, Japanese, and Korean traditional medicine. However, Sumbe khamba Ishbaljir in his book "ngos 'dzin shel dkar me long" wrote shogandha in Sanskrit and baspru in Tibetan. On the other hand, Toin Jambaldorj noted in his book "mtshar mig rgyan" wrote Paeonia anomala L. has warm and equable quality, so it can create power. Therefore, it is appropriate to write that the use of this plant in traditional Mongolian medicine is mainly used to treat back pain, chronic kidney disease, arthritis, uterine benign tumor, and bladder stone.

Keywords: Paeonia anomala L., traditional medicine, chronic kidney disease, arthritis

Оршил

Хориннэгдүгээр зууны Монголын уламжлалт анагаах ухааны эм зүй, эм судлалын хөгжлийн

үндэс нь өмнөх үеийн эмч, маарамбуудын бүтээн туурвисан анагаах ухааны эртний ном, судруудыг уншиж судлах, уг номуудад байгаа практик хэрэглээ нь өндөр боловч бага

Судалгаа, шинжилгээ

судлагдсан эмчилгээний зарим аргын орчин цагийн шинжлэх ухааны үндсийг тогтоох, гүнзгийрүүлэн ойлгох, тэдний гарын авлагын гүн уттыг оновтой тайлбарлахад оршиж байна. Энэ чиглэлийн судалгааны ажлын үр дүнг нэгтгэж, дорно дахины анагаах ухааны судар бичгийн түүхчилсэн тойм, ургамал амьтан, эрдсийн шинжлэх ухааны нэршлийг тодорхойлох, уламжлалт эмнэлэгт хэрэглэж ирсэн заалт, амт чадлыг нэгтгэн олон арван ном, гарын авлага бичиж нийтийн хүртээл болгосон байна. Түүнчлэн олон арван зүйл ургамлын фитохимиийн судалгааг манай судлаачид хийж гүйцэтгэнээс цахилдаг, хавраг, чонын өргөсийн төрлийн ургамлаас урьд нь шинжлэх ухаанд мэдэгдээгүй байсан 60-иад уламжлалын бодисуудыг нээн илрүүлж тодорхойлсон байна. Тэдгээрийн 18-ыг нь сүүлийн 54 жилийн хугацаанд гадаадын эрдэмтэдтэй хамтран таньж тодорхойлж үр дүнгээ нийтлүүлсэн байна. Эдгээрийн дотор уламжлалт анагаах ухааны эм найрлагад өргөн хэрэглэдэг цээнийн төрлийн ургамлын гол нэгдлүүдийг тогтоожээ. Тухайлбал Э.Пүрэвдорж, Г.Одонтuya (2016), Г.Одонтuya (2021) нар Цагаан цээнэ (*Paeonia lactiflora Pall.*) ба Ягаан цээнэ (*Paeonia anomala L.*)-ийн газрын дээд хэсэг, цэцэг, үндэсний химиин бүрэлдэхүүн, найрлагыг нарийвчлан судалсны дунд энэ хоёр зүйл ургамал нь химиин бүрэлдэхүүнээрээ хоорондоо төсөөтэй ба биологийн идэвхт гол нэгдлүүд ч ижил байна. Гэхдээ Ягаан цээнийн эмийн түүхий эд дэх биологийн идэвхит гол нэгдлүүд нь Цагаан цээнийхээс их хэмжээтэй байна гэдгийг тогтоожээ [1].

Тиймээс Ягаан цээнэд агуулагдах химиин гол болон дагалдах найрлагын тухайлсан өвчинд үзүүлэх үйлдлийг тогтоох, нарийвчлан судлах, ялангуяа уг ургамлын хэрэглээг уламжлалт анагаах ухааны сурвалж бичиг, судар номоос

тодруулах, үндсэн зургаан өвчний аль гэмийг анагаахад хэрэглэж байсныг тодруулах нь практикийн ихээхэн ач холбогдолтой юм.

Судалгааны ажлын зорилго

Ягаан цээнэ (*Paeonia anomala L.*)-ийн талаар бичсэн монгол эмч, маарамба нарын эртний судар номын мэдээллийг харьцуулан судалж амт, чадал, чанар, эрдмийг тодруулах

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга

1. Судалгааны хэрэглэгдэхүүн

- Сүмбэ хамба Ишбалжир. “Анагаах засал рашааны урсгалын нэмэлт хэсгийн доторх эм тус бүрийг илт өгүүлэх хийгээд танин мэдэх цагаан болор толь хэмээх оршивай”. Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)

- Тойн Жамбалдорж. Анагаан үйлдэх рашааныг эндуурэл үгүй танин мэдэх урлах ухааны толинд машид илэрсэн гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай (gso byed bduud rt-si'i 'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)

2. Судалгааны арга

- Эх зохиол судлах арга

Аливаа нэгэн судалгааны ажлыг хийхэд хамгийн түрүүнд хэрэглэгддэг арга нь эх зохиолыг судлах арга юм. Бид эрт цагийн маарамба, эмч, эрдэмтэн мэргэдийн бичиж туурвисан судар ном, бэсрэг бүтээлүүд зэрэг мэдээллийн эх сурвалжтай ажиллах үедээ уг аргыг ашиглав.

- Харьцуулах арга

Харьцуулах гэдэг нь нэг үзэгдэл юмс нөгөө үзэгдэл юмсаас юугаараа ялгаатай, юугаараа



адил төстэй болохыг танин мэдэж, тэдгээрийн нийтлэг ба онцлог шинжийг нээн харуулах боломж олгодог. Бид энэхүү аргыг ашиглан Ягаан цээнэ (*Paeonia anomala L.*)-ийн талаар бичсэн эмийн эртний судар номын мэдээллийг нэгтгэн дүгнэх бичигдсэн эртний судар, сүүлийн үеийн судалгааны ажлыг харьцуулан судалж ялгаатай, төсөөтэй талыг тогтоов.

- Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга

Сурвалж бичгийн доторх Ягаан цээнэ (*Paeonia anomala L.*)-ийн талаар бичсэн эмийн эртний судар төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгүүдийг бүрдүүлэхэд ашиглав. Магадлан жагсаах арга нь судлахууныг төрөлжүүлж ангилах, мэдээллийг цуглуулахад хялбар, үнэлгээний эхний шатны ажлыг гүйцэтгэх, төлөвлөсөн нийт ажлыг урьдчилан харах, цахим санд оруулахад зохимжтой, хялбар байдаг.

Үр дүн, хэлцэмж

1990 оноос эхлэн Монгол Улсад уламжлалт анагаах ухааны их эмч бэлтгэх бодлого хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ үеэс академич Ц.Хайдав, У.Лигаа, Б.Хүрэлчулуун БНХАУ-ын ӨМӨЗО-ны Лувсан нарын бүтээл, 2000 оноос хойш төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулийн уламжлалт анагаах ухааны ангид заах эм зүй, эм судлалын сурх бичгүүдэд хэвлэгдэж нийтийн хүртээл болсон. Эдгээр судлаачдын бүтээлийг нэгтгэн Ягаан цээнийн амт, чанар, чадал, үйлдлийг ерөнхийд нь тодруулав.

Монгол нэр: Ягаан цээнэ

Латин нэр: *Paeonia anomala L.*

Төвөд нэр: *ba spru*

Ерөнхий мэдээлэл: Холтсон цэцэгтэн (*Ranunculaceae*) овогт хамаарах 40-80 см өндөр

ургадаг, олон наст өвслөг ургамал. Үндэсний систем ихэд хөгжсөн. Бүдүүн түнтгэр үндэслэг иштэй. Навч нь үндэс орчмоосо гарсан урт бариултай, сарвуулаг, цуулбар, энгийн навчинцартай. Цэцэг нь хүрэн улаан өнгийн торгомсог дэлбээтэй.

Тархац: Монгол орны ургамал газарзүйн Хангай, Монгол-Алтай, Монгол Дагуур, Хэнтий, Хөвсгөлийн тойрогт хус, шинэсэн ойн гүнд буюу зарим нэгэн таг цармын бүслүүрт ургана.

Эмэнд хэрэглэх хэсэг: Үндэс, үндэслэг иш.


Агуулагдах бодис: Үндэс, үндэслэг ишинд сапонин, уураг, бага зэргийн эфирийн тос, органик хүчлүүд, эрдэс давс, витамин С, флавоноидын төрлийн бодис агуулагдана.

Амт, чанар: Амтлаг, гашуун, бүлээн, хөнгөн. **Үйлдэл, тус эрдэм:** Шээс хөөх, шимжүүлэх чадалтай. Шээс хаагдах, цус алдах, толгой өвдөх, хоол боловсруулах эрхтэний үйл ажиллагааг хямрах зэргийг засахаар хэрэглэнэ [2].



Ягаан цээнэ (*Paeonia anomala L.*)

Сүмбэ хамба Ишбалжир



мэдээллийг агуулж байна.

Зургаан үндэст: рани, нишин, басбруу (ягаан цээнэ), жава, лууван, сонгино буюу гаа орно.

Таван үндэст: рани, нишин, жава, басбруу (ягаан цээнэ), зангуу зэрэг болно. Үүнээс зангууг хасвал дөрвөн үндэс хэмээнэ.

Хоёр зүйлээр нэрлэдэг эмүүдийн дотроос гүгэл, сира (ସିରା), гүнжэд, шудаг, шапоруда (ଶପୋରୁଡା), гавар, чихэр өвс, жэрва (ଜେରବା), ағь, ягаан цээнэ (ଯାନ୍ତୁ), жилжэ, бүрүза (ବୁରୁଜା), сороол, даль, лалапүд, срадма (ଶ୍ରଦ୍ଧାମା), хилэнцэт хорхой, дабаг (ଦାବାଗ୍ରାହୀନ୍ତୁ), дагша, чацаргана зэргийг тус бүрд нь хар, цагаан хоёроор ялгана хэмээжээ. Мөн ягаан цээнийг санскритаар ашогандха (अशङ्कृ), төвөдөөр басбүрү (ବୁରୁଜା), цагааныг нь талбрай (ଚାନ୍ଦାରାଜା) гэнэ хэмээн нэрийн тайлбар хийсэн байна [3].

Тойн Жамбалдорж

Анагаан үйлдэх
рашааныг эндүүрэл
үгүйтанин мэдэх урлах
ухааны толинд машид
илэрсэн гайхамшигт
үзэсгэлэнт нүдэн
чимэг хэмээх оршивай
(gso byed bdud rts'i)


“Анагаах засал
рашааны урсгалын
нэмэлт хэсгийн доторх
эм тус бүрийг илт
өгүүлэх хийгээд танин
мэдэх цагаан болор
толь хэмээх оршивай”.
Модон барын төвөд
сударт ягаан цээний
талаар дараах

'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд сударт хүнд бөгөөд цагаан өнгөтэй дулэү буюу (сэргүүн) тиан хупуныг басбруү гэнэ.

Хийг арилгагч тосон эмийн салаанд задь, цагаан саримсаг, арүүр, барүүр, жүрүүр гурван үр, жаваа, рани, нэшин, басбруү, зангуу таван үндэс, манчэн нь хар бон-аа зэрэг таван навч орно.

Төвөдөөр ba spru, санскритаар ашогандха гэдэг. Уудам, нам дор газар ургах цайвар ногоон дүгрэг наалданхай будагт навчтай, нарийн эштэй талын шимэлдэг адил хэлбэртэй олон үет гол модтой. Цайвар улаан цэцэгтэй, танпром адил нарийн үндэстэй, гошуун амттай, цагаан буюу цайвар улаан цэцгийг хэрэглэнэ. Харавтар улаан цэцэгтэй бол эмд хэрэглэж болохгүй хэмээн номложээ. Эдүгээ үндэс нь танпромтай адил хэмээн эндүүрснээс Хятадын гвүлэү (gwu le'u) хэмээх сарлагийн зүрх адил үртэй дугтуйтын үндэс хийгээд маш хүнд цагаан, бүдүүн тинхуапин (thin hwa phin) хэмээн танин барьсан нь инээд алдмаар эндүүрэл болно. "Төмөр эрхис"-т:" ашогандха бол бүлээн, тэгш тул чадлыг үүсгэмүй" хэмээнээр биеийн доор хэсгийн хүйтэн ба шар усыг арилгана [4].

Ягаан цээнийн ялгаатай байдал



БНХАУ-ын ӨМӨЗО-ны эм судлалын судлаачид ягаан цээний оронд мэлрэг цэцгийг хэрэглэдэг. Нэрийг гол үндэслэл нь “Таван зүйлийн үсгээр хавсарсан Манж угний толь бичиг”-т мэлрэг цэцэг гэсэн нэрээр тэмдэглэсэнтэй холбоотой юм. Санскритаар ашогандха, төвөдөөр басбруү гэх өөр нэртэй гэсэн нь Монгол Улсад хэрэглэдэг ягаан цээнийн санскрит, төвөд нэртэй таарч байна. Ашогандха гэсэн санскрит



нэрийг нь “морины үнэрт” гэсэн утгатай үг гэж тайлжээ. Тус ургамлын үндэс сэнгэг үнэртэй тул үнэрийг нь мөрдөж ийн нэрийджээ. Таван үндэсний нэг болох бөгөөд эмэнд хэрэглэхийг “Зуун найралт”-д эхлэн тэмдэглэсэн. Бор мэлрэгийн язгуурын олон наст өвслөг ургамал Хималайн бор мэлрэг цэцгийг латинаар *Mirabilis himalaica* (Edgew.) Heim гэнэ. Мэлрэг цэцгийн хатаасан үндэс мөн гэж тодруулсан байна. Монгол Улсад мэлрэг цэцгийн оронд *Raeonia anomala* L-ийг хэрэглэдэг.

Хималайн бор мэлрэг цэцэг бол далайн түвшинээс 2900-3300 метр өндөр уулын бэлийн хатуулаг бэлчээр, атар газрын хөвөө, бут сөөг, ой шугуйтай газарт ургана. БНХАУ-ын Төвөд, Сичуань, Юнань зэрэг муж орон, жич Энэтхэгт ургадаг. Намар үндсийг нь малтан авч угааж цэвэрлэн гадна хальсыг нь хусч гарган хэрчиж наранд хатаана. Мэлрэг цэцгийн үндэс нь бөөрөнхий багана хэлбэртэй, хөндлөн буюу голоор нь зүссэн эмх замbaraагүй хэсэгтэй хавтгай хэрчим адил юм. Том жижиг нь адилгүй, хөндлөн хэрчим нь бөөрөнхий багана хэлбэр буюу диаметраараа 4 см хүрэх ч байдаг. Өнгөн тал нь саарал хүрэн буюу улбар хүрэн өнгөтэй. Арзгар, голт ховилтой, ар болон хөндлөнгөөрөө уртавтар хальсан сүв шиг гүдгэр, салбар үндэсний оромтой байдаг. Хатуу, хялбар хугарахгүй, хугарсан тал нь цайвар өнгөтэй, хотгор гүдгэр нь тэгшгүй, цагираг артай, нойтон, ялимгүй үл мэдэгдэм шорооны шинэ үнэртэй.

Мэлрэг цэцэг бол амтлаг, гошуун амттай. Бүлээн, хөнгөн, хуурай чанартай. Бөөрний хүйтэн, шар усыг арилгах, чулууширсан бэтгийг эвдэх чадалтай. Голдуу бөөрний хүйтнээр хөл нуруу өвдөх, бөөрний архаг, бөөрний дарган, үе гишүүний шар усны өвчин, умайн бэтэг, давсагны чулуун бэтэг зэргийг засахад хэрэглэнэ. Хэрэглэхдээ мэлрэг

цэцгийг бөөрний хүйтнээр хөл нуруу өвдөх, дусал цувирах, шээс чавдагших, бөөрний архаг, бөөрний дарган өвчинд ганц тангаар буюу мухар цагаан, хэрээн нүд, ямаан зангуу мэтийн бөөрний хүйтэн хийг арилгах эмүүдтэй хавсаргаж Таван үндэсний тосон эмд хөл болгож хэрэглэх, арьс махны завсрын шар усан өвчин, ясанд шунасан шар усны өвчинд шар мод, догол өвс, цагаан гүгэл мэтийн шар усыг арилгах эмүүд болон аруү мэтийн махбодыг тэгшигтгэх эмтэй хавсаргаж Мэлрэг цэцэг-5 танд голлогч эм болгож хэрэглэнэ. Хий бүрэлдсэн өвчин, умайн бэтэг, давсагны чулуун бэтэг, шээс хаагдсанд гал шуу мэтийн бэтгийг эвдэх эм, чацаргана мэтийн цусыг шингэлэх эм, гишүүнэ мэтийн туулгах эм, хар могой мэтийн хаагдсаныг нэвтлэх эмтэй хавсруулж Мэлрэг цэцэг-7-д голлогч эм болгож хэрэглэх болно. Ерөнхийдөө тан, талх зэрэг олон эмэнд уух эмэнд хөл эм болгоно [5].

Судлаач Г.Эрдэнэжав нар бүтээлдээ “Ягаан цээнэ (*Raeonia anomala*), оросоор *Марьин корень* гэдэг. 60-80см өндөр иштэй, гуравласан цуулбар навч, том ягаан цэцэгтэй олон наст өвслөг ургамал. Монгол орны хангай, хэнтийн уулархаг нутгийн шинс, хусан холимог ойн зах, цоорхойгоор ургадаг. Мал иддэггүй. Цээнийн навч үндсийг хүнсэнд хэрэглэдэг байна гэжээ [6]. Мөн ягаан цээнэ нь олон наст өвслөг ургамал. Үндэс, үндэслэг ишний хэсгээр үрждэг. Монгол уламжлалт анагаах ухаанд амтлаг, халуун, чадал нь бүлээн, хуурай, хөнгөн, үйлдэл нь бөөрний илч доройдох, биеийн хүчийг сэлбэх, цайвар хаван, шар ус, эмэгтэйн өвчин, цагаан юм ихдэх, шээсний замын өвчин, түрүү булчирхайн өвчин, боом, гал хавдар, үенд шар ус хурах, чулуун бэтэгт тустай гэх мэтээр бичсэн байна [7]. Зарим эх сурвалжид умайн улайлт, саажилт, унадаг өвчин, гар хөл чичрэх, нойр-гүйдэл, тархинд цус харвах, шээс задгайрах,

түрүү булчирхай, уушигны үрэвсэл, хodoодны шархлаа, цус өтгөрөлт, ой тогтоолт, бамбай булчирхайд хэрэглэнэ. Цагаан цээнийг халуун ханиад, ханиалгах, уушгины янз бүрийн өвчин, цэр ховхлох, бөөрний өвчин, шээс задгайрах, хodoодны шархлаа, шулуун гэдэсний үрэвслийн өвдөлтийг зогсоох, мэдрэлийн өвчнийг тайвшруулах, хөгшрөлтийг удаашруулахад хэрэглэнэ. Эмийн найрлаганд оруулахын тулд намар есдүгээр сарын эхээр түүж, хатаадаг. Цээнийн ягаан цэцэгнээс “согоон сав”-ыг гаргаж авдаг бөгөөд тэр нь тус цэцгийн үрийн хонхорцог юм хэмээн хэрэглээг нь уламжлалт анагаах ухаанд гэхээсээ илүүтэй орчин цагийн анагаах ухааны хэрэглээг нэмж илүү өргөн хэрэглээтэй байдлаар онцлон дурджээ.

Ягаан цээнийг умайн улайлт, саажилт, унадаг өвчин, гар хөл чичрэх, нойргүйдэл, тархинд цус харвах, шээс задгайрах, түрүү булчирхай, уушигны үрэвсэл, хodoодны шархлаа, цус өтгөрөлт, ой тогтоолт, бамбай булчирхайд мөн цагаан юм, шамбарам (угааж шавшина), бөөр, сав, өндгөвч, усан хаван, биеийн юм саатах, ууц нуруугаар өвдөхөд хэрэглэнэ [8].

Ягаан цээнэ (*Paeonia anomala L.*) нь Монгол, Төвөдийн уламжлалт анагаах ухаанд цусан халууныг арилгах, бүрэлдсэн цусыг тараах, өвдөлт намдаах, хэвлэлийн бэтэг, хорт хавдар, шоргоолжин хатиг, үе мөч өвдөж хавдах зэргийг засахад хэрэглэдэг байжээ [9] гэх мэтээр хэрэглээ талаас нь олон янзаар бичжээ. Ягаан цээнийн хэрэглээг ингэж олон янзаар, өргөн хүрээтэй бичсэн нь уламжлалт анагаах ухаан, ардын эмнэлэг, орос ардын эмнэлэг, Хятад, Япон, Солонгосын уламжлалт анагаах ухаанд хэрэглэх заалтаас нь баяжуулсантай холбоотой байна. Чухамдаа Сүмбэ хамба Ишбалжир “Цагаан болор толь”-д бичсэн санскритаар ашогандха (अशङ्का), төвөдөөр

басбүрүг (बस्तु) хэмээн [10] бичсэн нэрийн дор, Тойн Жамбалдорж “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т бүлээн, тэгш тул чадлыг үүсгэмүй” хэмээнсээр биеийн доор хэсгийн хүйтэн ба шар усыг арилгана [11] гэснийг баримтлан Ягаан цээнэ (*Paeonia anomala L.*)-ийг хэрэглэх нь зүйд нийцнэ. Үүнийг тодруулбал ягаан цээнэ бол амтлаг, гошуун амттай. Бүлээн, хөнгөн, хуурай чанартай. Бөөрний хүйтэн, шар усыг арилгах, чулуун бэлгийгэвдэх чадалтай. Голдуу бөөрний хүйтнээр хөл нуруу өвдөх, бөөрний архаг, бөөрний дарган, үе гишүүний шар усны өвчин, умайн бэтэг, давсагны чулуун бэлгийг засна гэж Монголын уламжлалт анагаах ухааны хэрэглэх заалтыг нь цэцлэх нь оновчтой юм.

Ном зүй

1. Э.Пүрэвдорж, Г.Одонтuya. Цээнийн төрлийн ургамал дахь гол нэгдлүүд. ШУА-ийн мэдээ. 2016, №1(217), Vol 56, x.91-101
2. Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал. Ерөнхий редактор, академич Ш.Болд. УБ, 2014, x.233
3. Сүмбэ хамба Ишбалжир. “Анагаах засал рашааны урсгалын нэмэлт хэсгийн доторх эм тус бүрийг илт өгүүлэх хийгээд танин мэдэх цагаан болор толь хэмээх оршивай”. Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)
4. Тойн Жамбалдорж. Анагаан үйлдэх рашааныг эндуүрэл үгүй танин мэдэх урлах ухааны толинд машид илэрсэн гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай (gso byed bdud rtsi'i 'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)



5. Монгол судлалын нэвтэрхий толь. ӨМ-ын Ардын хэвлэлийн хороо, х.531
6. Г.Эрдэнэжав, Г.Балдандорж, С.Тусивах. БНМАУ-ын тэжээлийн голлох ургамлын өнгөт альбом 1. УБ, 1974, х.168
7. Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах. УБ, 2003, х.162
8. Ямар эмийн ургамал юунд тустай болохыг мэдэж. <https://news.gegee.one>.
9. М.Биндэрья, М.Бөхчулуу, Ц.Бямбасүрэн, Г.Жаргалсайхан. Сагсай чонын өргөс (*Carduus Crispus L.*), Бөхөөн чонын өргөс (*Carduus Nutans L.*), Яагаан цээнэ (*Paeonia Anomala L.*), Ороодог хорс (*Aconitum Volubile Pall.*), Хар агширгана (*Veratrum Nitrum L.*), Зайсангийн заг (*Haloxylon Ammodendron*) эмийн ургамлуудын элементийн судалгаа. “Монголын анагаах ухаан” 2008, №2 (144), х.59-61
10. Сүмбэ хамба Ишбалжир. “Анагаах засал рашааны урсгалын нэмэлт хэсгийн доторх эм тус бүрийг илт өгүүлэх хийгээд танин мэдэх цагаан болор толь хэмээх оршивай”. Модон барын төвөд судар
11. Тойн Жамбалдорж. Анагаан үйлдэх рашааныг эндүүрэл үгүй танин мэдэх урлах ухааны толинд машид илэрсэн гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай (gso byed bdud rts'i'i 'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗҮ-ы доктор, профессор Э.Сэлэнгэ